ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ЗАА-2026/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2026 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанжаргал
Утас: 92012266
Цахим хаяг: Baasanjargalt@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-3612
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.03.24 № 240

танай ______________ -ны № ______________ -т

ОТГОН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БАТ-ОРГИЛД

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Отгон сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Отгон сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Отгон сумын Засаг дарга нь Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг хэсэгчилж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, мөн худалдан авсан хөрөнгийг орлогод бүртгээгүй, Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан гэх зөрчилд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагаа хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4-т "Сум дүүргийн Засаг даргын чиг үүрэг", 3.4.3-т "Сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих" ", Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.4 "Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 3.4.3 "энэ журмын 3.4.2-т заасан төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэнтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын

D:\Албан бичиг\А4-2026.docx

хяналт тавих", 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд татвар болон татварын бус орлого 107,447.9 мянган төгрөгөөр, урсгал санхүүжилтийн орлого 114,08.0 мянган төгрөгөөр тус тус өссөн, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 8,597.2 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 68,956.7 мянган төгрөгөөр, улсын төсөвт байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгох байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт 92,784.9 мянган төгрөгөөр буурсан тус тус буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Отгон сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд сумын Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сан болон Засаг даргын нөөц сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 92,757.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Отгон сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 526,272.1 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 592,046.3 мянган төгрөг буюу 112.5 хувьтай байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 26,979.6 мянган төгрөгийг 25 иргэнд буцаан олгосон байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *Ӏмянган төгрөгөөрӀ*

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 752,757.4 | 863,431.1 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 553,887.9 | 656,250.3 |
| 3 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 86,391.2 | 95,595.1 |
| 4 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 112,478.3 | 111,585.7 |
| 5 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,078,561.5 | 1,226,440 |
| 6 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 1,078,561.5 | 1,226,440 |
| 7 | Биет хөрөнгө | | 1,070,875.5 | 1,219,074 |
| 8 | Биет бус хөрөнгө | 13 | 7,686 | 7,366 |
| 9 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | | 1,831,318.8 | 2,089,871.1 |
| 10 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 0.0 | 10,867.5 |
| 11 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 0.0 | 10,867.5 |
| 12 | Өглөг | | 0.0 | 10,867.5 |
| 13 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 1,831,318.8 | 2,079,003.6 |
| 14 | Засгийн газрын хувь оролцоо | | 1,831,318.8 | 2,079,003.6 |
| 15 | Засгийн газрын оруулсан капитал | | 782,776.2 | 782,776.2 |
| 16 | Хуримтлагдсан үр | | 836,126.9 | 950,978.8 |
| 17 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 212,415.8 | 345,248.6 |
| 18 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | | 1,831,318.8 | 2,089,871.1 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *Ӏмянган төгрөгөөрӀ*

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 2,265,798 | 2,119,679.3 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 425,471.7 | 520,348.2 |
| 3 | Орлогын албан татвар | | 368,330.4 | 322,966.5 |
| 4 | Хувь хүний орлогын албан татвар | | 390,490.1 | 349,946.2 |
| 5 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -22,159.7 | -26,979.6 |
| 6 | Хөрөнгийн албан татвар | | 49,520.1 | 54,852.3 |
| 7 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 7,621.3 | 142,529.3 |
| 8 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 378,121.8 | 1,599,331.1 |
| 9 | Тусламжийн орлого | | 0.0 | 1,050,485.7 |
| 10 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,462,204.5 | 0.0 |
| 11 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 1,729,590.1 | 1,711,064.9 |
| 12 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,729,590.1 | 1,711,064.9 |
| 13 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,577,864.3 | 1,586,094.2 |
| 14 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 687,136.9 | 760,920 |
| 15 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 84,516.3 | 98,335.8 |
| 16 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 361,167.1 | 372,700.2 |
| 17 | Хангамж, бараа материалын зардал | | 53,745.4 | 55,717.2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 18 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 41,127.4 | 54,207.2 |
| 19 | Томилолт, зочны зардал | | 12,207.2 | 11,787.4 |
| 20 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 3,318.8 | 2,465.4 |
| 21 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 334,645.3 | 229,960.9 |
| 22 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 151,725.8 | 124,970.6 |
| 23 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 536,207.9 | 408,614.4 |
| 24 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 426,118.4 | 319,524 |
| 25 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | -426,118.4 | -319,524 |
| 26 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 110,089.5 | 89,090.5 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *(мянган төгрөгөөр)*

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл | 1,721,229.4 | 1,721,229.4 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,721,229.4 | 1,721,229.4 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | 110,089.5 | 110,089.5 |
| 4 | 2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл | 1,831,318.8 | 1,831,318.8 |
| 5 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,831,318.8 | 1,831,318.8 |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 25,761.5 | 25,761.5 |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,857,080.3 | 1,857,080.3 |
| 8 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 132,832.8 | 132,832.8 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 89,090.5 | 89,090.5 |
| 10 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 2,079,003.6 | 2,079,003.6 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* */мянган төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,043,239.8 | 2,017,807.4 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 425,471.7 | 520,348.2 |
| 3 | Орлогын албан татвар | 368,330.4 | 322,966.5 |
| 4 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -22,159.7 | -26,979.6 |
| 5 | Хөрөнгийн албан татвар | 49,520.1 | 54,852.3 |
| 6 | Бусад татвар, төлбөр, хураамж | 7,621.3 | 142,529.3 |
| 7 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,603.6 | 10,908 |
| 8 | Газрын төлбөр | 4,017.7 | 6,341.3 |
| 9 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 0.0 | 125,280 |
| 10 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 155,563.6 | 1,497,459.2 |
| 11 | Нийтлэг татварын бус орлого | 155,563.6 | 103,162 |
| 12 | Тусламжийн орлого | 0.0 | 1,050,485.7 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 343,811.5 |
| 14 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,462,204.5 | 0.0 |
| 15 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,575,070 | 1,523,074.1 |
| 16 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,575,070 | 1,523,074.1 |
| 17 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,423,344.2 | 1,398,103.4 |
| 18 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 684,866.7 | 759,153.1 |
| 19 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,516.3 | 96,261.9 |
| 20 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 360,647 | 372,777.1 |
| 21 | Хангамж, бараа материалын зардал | 50,769.1 | 46,805 |
| 22 | Эд хогшил, урсгал засварын зардал | 41,663.9 | 50,662.1 |
| 23 | Томилолт, зочны зардал | 12,207.2 | 6,777.8 |
| 24 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,296.9 | 2,445.4 |
| 25 | Бараа үйлчилгээний бусад зардал | 184,377.2 | 63,221.1 |
| 26 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 151,725.8 | 124,970.6 |
| 27 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 468,169.8 | 494,733.3 |
| 28 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 438,778.4 | 319,524 |
| 29 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 438,778.4 | 319,524 |
| 30 | Дотоод эх үүсвэрээр | 438,778.4 | 319,524 |
| 31 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -438,778.4 | -319,524 |
| 32 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 2,790.2 | 72,846.9 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *(мянган төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,260,349.7 | 1,929,462.6 |
| 2 | Татварын орлого | 496,292.4 | 520,348.2 |
| 3 | Орлогын албан татвар | 425,002.4 | 322,966.5 |
| 4 | Хувь хүний орлогын албан татвар | 449,162.1 | 349,946.2 |
| 5 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 318,483.5 | 294,282.5 |
| 6 | Үйл ажиллагааны орлого | 22,000 | 8,229 |
| 7 | Хөрөнгийн орлого | 92,200 | 0.0 |
| 8 | Хөрөнгө борлуулсны орлого | 1,800 | 0.0 |
| 9 | Шууд бус орлого | 14,678.6 | 47,434.7 |
| 10 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -24,159.7 | -26,979.6 |
| 11 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -24,159.7 | -26,979.6 |
| 12 | Хөрөнгийн албан татвар | 48,740 | 54,852.3 |
| 13 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 2,200 | 21,534 |
| 14 | Бууны албан татвар | 1,540 | 3,510 |
| 15 | Малд ногдуулах албан татвар | 45,000 | 29,808.3 |
| 16 | Бусад татвар, төлбөр, хураамж | 22,550 | 142,529.3 |
| 17 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,250 | 10,908 |
| 18 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,450 | 8,398 |
| 19 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 300 | 1,000 |
| 20 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1,500 | 1,510 |
| 21 | Газрын төлбөр | 19,000 | 6,341.3 |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | Газрын төлбөр | 19,000 | 6,341.3 |
| 23 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 300 | 125,280 |
| 24 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 0.0 | 125,280 |
| 25 | рашааны нөөц ашигласны төлбөр | 300 | 0.0 |
| 26 | Татварын бус орлого | 1,308,952.4 | 999,929.7 |
| 27 | Нийтлэг татварын бус орлого | 3,000 | 103,162 |
| 28 | Хүүгийн орлого | 0.0 | 42,609 |
| 29 | Торгуулийн орлого | 3,000 | 2,110 |
| 30 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 0.0 | 58,443 |
| 31 | Тусламжийн орлого | 972,140.9 | 552,956.2 |
| 32 | Аймаг нийслэлээс авсан татаас | 972,140.9 | 552,956.2 |
| 33 | Төсвийн санхүүжилт | 409,184.7 | 409,184.7 |
| 34 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 343,811.5 | 343,811.5 |
| 35 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,260,349.7 | 1,737,342.9 |
| 36 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,544,833.3 | 1,344,972.0 |
| 37 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,535,573.3 | 1,344,372 |
| 38 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 772,040.5 | 759,153.1 |
| 39 | Үндсэн цалин | 432,109.5 | 430,100.1 |
| 40 | Нэмэгдэл | 265,491.9 | 271,848.1 |
| 41 | Урамшуулал | 74,439.1 | 57,204.9 |
| 42 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 96,505.3 | 96,261.9 |
| 43 | Тэтгэврийн даатгал | 65,623.5 | 64,963.9 |
| 44 | Тэтгэмжийн даатгал | 7,720.4 | 7,720.4 |
| 45 | ҮОМШӨ-ний даатгал | 3,860.3 | 4,306.5 |
| 46 | Ажилгүйдлийн даатгал | 3,860.3 | 3,830.3 |
| 47 | Эрүүл мэндийн даатгал | 15,440.8 | 15,440.8 |
| 48 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 462,634.5 | 372,777.1 |
| 49 | Гэрэл, цахилгаан | 58,302.7 | 33,754.6 |
| 50 | Түлш, халаалт | 399,013.7 | 330,947 |
| 51 | Цэвэр, бохир ус | 5,318.1 | 8,075.5 |
| 52 | Хангамж, бараа материалын зардал | 48,562.3 | 38,099.9 |
| 53 | Бичиг хэрэг | 5,923.5 | 5,598 |
| 54 | Тээвэр, шатахуун | 37,420.2 | 28,746.5 |
| 55 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,218.6 | 3,755.4 |
| 56 | Эд хогшил, урсгал засварын зардал | 52,462.4 | 46,776.1 |
| 57 | Багаж, техник, хэрэгсэл | 3,500 | 0.0 |
| 58 | Урсгал засвар | 48,962.4 | 46,776.1 |
| 59 | Томилолт, зочны зардал | 6,928.5 | 6,777.8 |
| 60 | Дотоод албан томилолт | 6,928.5 | 6,777.8 |
| 61 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,012.3 | 1,871.7 |
| 62 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,900 | 1,085 |
| 63 | Даатгалын үйлчилгээ | 469.1 | 368.1 |
| 64 | Тээврийн хэрэгслийн татвар | 227.7 | 215.2 |
| 65 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73.8 | 0.0 |
| 66 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 203.4 | 203.4 |
| 67 | Газрын төлбөр | 138.3 | 0.0 |
| 68 | Бараа үйлчилгээний бусад зардал | 93,427.5 | 22,654.4 |
| 69 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,377.5 | 21,615.8 |
| 70 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,050 | 1,038.6 |
| 71 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,260 | 600.0 |
| 74 | Бусад урсгал шилжүүлэг | 9,260 | 600.0 |
| 75 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,260 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 76 | 3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000 | 600.0 |
| 77 | 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 545,516.4 | 319,524 |
| 78 | 3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө | 545,516.4 | 319,524 |
| 79 | 3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 170,000 | 72,846.9 |
| 80 | 3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл | 170,000 | 72,846.9 |
| 81 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -455,104.9 | 102,362.4 |
| 82 | 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 455,104.9 | -102,362.4 |
| 83 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 455,104.9 | -102,362.4 |
| 84 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 553,887.9 |
| 85 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 656,250.3 |
| 86 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 46 | 21 |
| 87 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 0.0 |
| 88 | 6.1.01 Төсвийн байгууллага | 2 | 0.0 |
| 89 | 6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО | 22 | 21 |
| 90 | 6.2.01 Удирдах ажилтан | 11 | 9 |
| 91 | 6.2.02 Гүйцэтгэх ажилтан | 8 | 10 |
| 92 | 6.2.03 Үйлчлэх ажилтан | 3 | 2 |
| 93 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 22 | 0.0 |
| 94 | 6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 0.0 |
| 95 | 6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4 | 0.0 |
| 96 | 6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ) | 9 | 0.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/мянган төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 88,344.85 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 88,344.85 |
| 122 | Тусламжийн орлого | 88,344.85 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 88,344.85 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 88,344.85 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 88,344.85 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 53,731.46 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 53,731.46 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 53,731.46 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,705.09 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,705.09 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,886.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,886.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 573.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 573.67 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,566.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,566.70 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 34,613.39 |

| | | |
|---|---|---|
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (34,613.39) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 34,613.39) |

## 3 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой 92.75 сая төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзэж, 43.15 сая төгрөгийн тогтоосон материаллаг байдлын түвшнээс 49.60 сая төгрөгөөр их, илэрсэн зөрчлийн хэмжээ өргөн тархсан тул "Сөрөг " дүгнэлт өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар Отгон сумын Засаг дарга нь Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг хэсэгчилж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, мөн худалдан авсан хөрөнгийг орлогод бүртгээгүй, Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан 92.75 сая төгрөгийн зөрчилд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгсөн.

### 3.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчил илрээгүй байна.

**Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Отгон сумын ЗДТГ | 2.00 | 86,252.78 | | | 2.00 | 86,252.78 | 2.00 | 86,252.78 | | | | |
| Отгон н сумын ИТХ | 2.00 | 1,213.59 | | | 2.00 | 1,213.59 | 2.00 | 1,213.59 | | | | |
| Отгон сумын ОНХС | | | | | | | | | | | | |
| Отгон сумын ХХС | | | | | | | | | | | | |
| Отгон сумын Засаг дарга | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **87,466.37** | **4** | **87,466.37** | **4** | **87,466.37** | **4** | **87,466.37** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | | Үүнээс Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үүнээс Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТТ | Тоо | Дүн |
| Отгон сумын ЗДТГ | 2.00 | 3,098.00 | | | 2.00 | 3,098.00 | | | | | | |
| Отгон сумын ИТХ | | | | | | | | | | | | |
| Отгон сумын ОНХС | 4.00 | 65,290.00 | | | 4.00 | 65,290.00 | | | | | | |
| Отгон сумын ХХС | 1.00 | 24,369.14 | | | 1.00 | 24,369.14 | | | | | | |
| Отгон сумын Засаг дарга | 2 | 92,757.14 | | | 1 | 92,757.14 | | | 1 | | | |
| **Дүн** | **9** | **185,514.28** | | | **8** | **185,514.28** | | | **1** | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | Үүнээс Төлбөрийн акт | Үүнээс Албан шаардлага | Үүнээс Зөвлөмж | Үүнээс Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |
|---|---|---|---|---|---|

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт гаргахаас татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 4 | | 4 | | | | | |
| 2 | ТТЗ | 1 | 1 | | | | | 1 | |
| | **НИЙТ** | **5** | **1** | **4** | | | | **1** | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

Огноо: 2026-03-25

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР Т.БААСАНЖАРГАЛ

Огноо: 2026-03-25